

ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА

Н.Содномцог*

Олон улсын худалдааны тухай асуудлыг авч үзэхийн тулд худалдаа гэдэг ухагдахууныг тодруулъя. “Худалдаа” гэдэг нь “de commerce” гэдэг латин үгнээс гаралтай. Худалдааг хуульчид, эдийн засагчид болон эрдэмтэн судлаачид янз бүрээр тодорхойлдог. Тэдгээр ойлголтуудаас нэгтгэн дүгнэж товчоор хэлбэл “Худалдаа бол солилцоо” юм гэхэд зөрчилдөхгүй байхаа. Энэ солилцоо нь өрхийн хэрэгцээнээс эхлээд нэг орны болон олон улсын, бүс нутгийн хэмжээнд харилцан явагдаж, хүний нийгмийн хөгжлийн жамаар цар хүрээгээ тэлж өргөжин улам боловсронгуй болон хөгжиж, даян дэлхийг хамрах болов. Дэлхийн хамгийн буурай ядуу орон ч байлаа, үйлдвэрийн хамгийн хөгжилтэй, хөгжингүй, эдийн засгийн хувьд баян орон байлаа ч өөр өөрсдийн хязгаарлагдмал нөөцөөр хэмжээлшгүй хэрэгцээгээ дангаараа хангаж чадахгүй. Энэхүү хэрэгцээг хангахын тулд улс орныхоо харьцангуй болон туйлын (унаган, олдмол) давуу талыг бодолцон үйлдвэрлэлээ сонгон явуулж, нөөцөө нэмэгдүүлэн экспортолж дутуугаа нөхөхөөр тэрээр бараа импортлох шаардлагатай. Эдийн засгийн маань хязгаарлагдмал нөөцөөс ЮУГ, ЯАЖ, ХЭНД зориулан үйлдвэрлэх аргыг сонгон судалж олох нь нэг талаас шинжлэх ухааны асуудал, нөгөө талаас эдийн засгийн цөм асуудал юм. Ийнхүү эдийн засгийн асуудал бол хүн төрөлхтний аж амьдрал, хөгжил дэвшлийн бүхий л талтай холбоотой байдгаас үзэхэд худалдааны үндэс суурь болж байдаг.

Ямар ч улс орны амьдрал өдөр тутамдаа 3 үндсэн асуудлыг шийдвэрлэж байхыг шаарддаг. Энэ “зах зээл, үйлдвэрлэл, хуваарилалт” гэсэн ойлголтоор илэрхийлдэг, өөрөөр хэлбэл зах зээл нь ЮУГ, үйлдвэрлэл гэдэг нь ЯАЖ, хуваарилалт гэдэг нь ХЭНД, тухайлбал “ЮУГ-ЯАЖ-ХЭНД” гэсэн дэс дарааллаар аливаа хэрэгцээг хангах үйл ажиллагааны сургаал бий.

Улс орны нийгэм эдийн засгийн байгуулалт, түүний материаллаг баазыг тодорхойлсон нийгмийн үйлдвэрлэлийн харилцааны түүхэн тодорхой иж бүрэн

* МУИС-ийн ОУХС-ийн багш

асуудлыг эдийн засаг өөрөө агуулсан байдаг. Эдгээр асуудлын дотроос гадаад худалдаа нь тухайн орны эдийн засгийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирлээ. Тиймээс ч дэлхийн улс орнууд гадаад худалдаа хийх зайлшгүй шаардлагатай тулгарч байдаг. Хоёр орны хувьд авч үзвэл гадаад худалдаа нь барааны экспорт (гадагш гаргах), импортын (дотогш оруулах) үйл ажиллагаа юм. Мэдээжийн хэрэг л дээ гадаад худалдаа хийх хэрэгтэй. Харин хийхдээ тухайн худалдаанаас ашиг олж байх нь зайлшгүй. Ашиг нь их үү, бага уу, эсвэл алдагдалтай юу гэдэгт л худалдааны гол нь байдаг.

Улс орны гадаад худалдааны бодлого нь дараах 3 чиглэлээр явагддаг. Үүнд:

- Ямар бараа, үйлчилгээг экспортолж, юуг импортолж авах;
- Түүнийгээ сонгоод хэнтэй нь худалдаа хийх;
- Худаалдааг ямар хэмжээнд, ямар хугацаанд хийх

Гадаад худалдаа тун эртний бизнес учир худалдааны олон онол, зарчим өнөөг хүртэл томъёологдож байна. Олон улсын худалдааны талаар иж бүрэн судалгаа нь XVI дугаар зуун буюу меркантизмын үед эхэлсэн ба энэ талаар олон онолчид өөрийн үзэл бодлоо илэрхийлсээр ирсэн билээ.

Олон улсын худалдаа нь улс хоорондын эдийн засгийн гадаад харилцааг хэрэгжүүлдэг худалдаа, хөрөнгө оруулалт мэдээлэл болон технологийн солилцоо, олон улсын техник туслалцаа зэргийн дотроос хамгийн зонхилох хэлбэрт зүй ёсоор ордог билээ. Нийгэм эдийн засгийн хөгжлийн олон янзын түвшинд оршиж буй дэлхийн улс орнуудын хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ, түүнийг хангаж байдаг үйлдвэрлэл оршин байгаа нь олон улсын худалдаа хийх үндсэн нөхцөл болж байдаг. Олон улсын худалдаа бол дэлхийн бүх улс орнуудын гадаад худалдааг хамарсан олон улсын таваар, мөнгөний харилцааны хүрээ болно. Орчин үеийн улс орны хоорондын худалдаа бол удирдлага зохион байгуулалт, техник технологи, хууль эрх зүй, шинжилгээ судалгаа, төлбөр тооцоо, тээвэрлэлт, хадгалалт, чанар стандарт, эрүүл ахуй, хорио цээрийн хяналт, хил гааль гэх мэт үйл ажиллагааны асар өргөн цар хүрээг хамарч явагддаг нарийн нэгдмэл үйл ажиллагаа юм.

Улс орнуудын дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь тухайн орнуудын эдийн засгийн салбаруудын хөгжилт, худалдааны тодорхой пүүсүүдийн үйл

ажиллагааны ололт амжилтаас шууд хамаарна. Улс орнуудын хооронд бараа худалдах үйл ажиллагаа нь янз бүрийн хөгжилтэй улс орны том, жижиг пүүсүүдээс хийж буй гадаад худалдаагаар дамжин хэрэгждэг билээ. Нээлттэй эдийн засгийн тогтолцоонд өмчийн бүхий л хэвшлийн зохион байгуулалтын тодорхой түвшинд аж ахуйн нэгжүүд гадаад худалдаа эрхлэх болон бараа үйлчилгээг экспортлох, импортлох эрхээр хангагдсан байдаг. Тэрхүү эрхээ хир зэрэг амжилттай хэрэгжүүлэх нь гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүд экспорт, импортын операциудыг хэрхэн амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлж байгаагаар илрэн харагддаг байна. Олонх экспортын болон импортын компаниудын хувьд дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх боломж нь хязгаарлагдмал байдаг учир борлуулалт, ашгаа нэмэгдүүлэхийн тулд олон улсын зах зээл дэх эрэлтийн боломжийг ашиглахыг зорьдог. Бизнесийн байгууллагууд гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцох шалтгаан, нөхцөл байдлаас хамаарч өөрөөр байж болно. Олон улсын худалдаанд бараа таваар солилцохын зэрэгцээгээр зарим орон голчлон аялал жуулчлалаар орлого олдог. Олон улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаагаар дамжин даяарчлагдаж байгаа өнөө үед олон улсын худалдаа нь дэлхийн эдийн засгийн ололтоос хавьгүй илүү түргэн хурдацтай өсч, эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл болсоор ирсэн, болж ч байна.

Өөрийн оронд үйлдвэрийн бараа таваар, үйлчилгээг экспортолж оронд нь үйлдвэрлэхэд харьцангуй үр ашигтай бараа бүтээгдэхүүнийг импортлож байдаг. Зарим орон дотоодын нийт бүтээгдэхүүний заримыг хилийн чанадад бүтээх нь үр дүнгээ өгч байгаагаас үзэхэд цаашид хүрээгээ тэлэх хандлагатай байна.

Дэлхийн аж ахуйн систем нь олон улсын худалдаагаар дамжин харилцан уялдаатай, харилцан ойлголцсон, харилцан шүтэлцээтэйгээр хөгжиж, улам ойртон нягтрах, даяарших үйл явцаар тодорхойлогдож байна. Дэлхийн худалдаанд оролцогч орны ашиг болон алдагдлыг худалдааны нөхцлийн индексээр тодорхойлдог.

$$\text{Индекс} = \frac{\text{экспорт}}{\text{импорт}} > < 1$$

Энэ нь 1-ээс их байвал тухайн орон дэлхийн бараа, үйлчилгээний зах зээл дээр ашигтай байна, харин 1-ээс бага байвал алдагдалтай байна гэсэн үг.

Дэлхийн худалдаанд оролцож байгаа тэргүүний хөгжилтэй орнуудын үйлчилгээний байгууллагууд тухайлбал; банк, даатгал, тээвэр, холбоо, харилцаа зэрэг нь нилээд ашигтай ажиллаж байна. Зардлыг хэмнэх үүднээс аливаа улс орон хөрш зэргэлдээ болон бүс нутгийн орнуудтай түншилж ажиллах нь илүү ашигтай байдаг нь харагдаж байна. Тэдгээр орнуудын байгаль цаг агаарын нөхцөл, зан заншил ойр байхаас гадна хөрш зэргэлдээ түншүүдын хооронд харилцан ойлголцох явдал харилцан шүтэлцээ нь бусдаас бүр илүү ойр дотно байдаг. Зарим тохиолдолд ч дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадваргүй бараа таваар, үйлчилгээ нь хөрш болон бүс нутгийн түншийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалан уг зах зээл дээр борлогдож байдаг.

Даяаршлын үе шатанд дэлхийн улс гүрний улс төр, эдийн засаг, худалдаа болон нийгмийн амьдрал улам бүр илүү уялдаатай, харилцан шүтэлцээтэй болохын зэрэгцээгээр нягтран нэгдмэл болж, аливаа бэрхшээл багасч худалдаа илүү чөлөөтэй болж, технологи дамжуулах капитал болон ажиллах хүчний шилжилтийн урсгал идэвхжиж, орон зайн болон улсын хилийн хязгаарлалт бүдгэрэх болов. Энэ нь Европын Холбооны улсуудын хоорондын үйл ажиллагаанд тод харагдаж байна. Томоохон орнуудын үндэс хальсан (дамнасан) корпорациуд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт хүрээгээ улам тэлсээр байна. Үүний зэрэгцээгээр аливаа орон өөрийн онцлог байгалийн баялаг, эрдэс түүхий эдээ ашиглан төрөлжин дагнах болон хорших хэлбэрээр бусад орнуудтай хамтран ашиглаж үндэсний үйлдвэрээ хөгжүүлж дэлхийн нийтлэг солилцоонд оролцож улмаар олон улсын хөдөлмөрийн хуваарьт зүй ёсоор оролцох боломж улам бүр нээгдсээр байна. Тэрээр нээлттэй эдийн засгийн болон чөлөөт худалдааны бодлогыг төр засгаас хүчтэй дэмжих нь тал бүрийн ашигтай болох нь цагийн аясаар улам нотлогдож байна.

Даян дэлхийн нийтлэг хамтын ажиллагаатай уялдан дэлхийн хэмжээнд худалдаа санхүү, эдийн засгийн тогтвортой байдал болон бизнесийн эрх чөлөөг хангах, өмчлөх эрхийг баталгаажуулах зэрэг нийтлэг хэм хэмжээний орчинг буй болгох, эрх зүйн нэгдсэн систем бүрдүүлэх, дэлхийн хэмжээнд чөлөөт худалдааны нэгдсэн эрх зүйн нөхцлийг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Дэлхийн худалдааны байгууллага чиглүүлэн идэвхтэй ажиллаж байна. Тэрээр Дэлхийн худалдааны байгууллага нь бусад олон улсын өөр байгууллагуудтай хамтран үндэсний макро

эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр зээл, тусламж үзүүлж байна. Үндэсний засгийн газар Дэлхийн худалдааны байгууллагын олон талт хэлэлцээрүүдээр хүлээсэн хариуцлагын хүрээнд өөрийн худалдааны эерэг болон сөрөг (чөлөөт худалдаа, протекционист худалдаа) бодлого нь илэрч байдаг. Улс орон дотоодын зах зээлээ хамгаалах үүднээс протекционист худалдааны бодлогыг тариф болон тарифийн бус хэлбэрээр явуулж ирлээ.

Олон улсын худалдааг дэлхийн барааны зах зээлгүйгээр төсөөлөх аргагүй юм. Барааны зах зээл нь арилжаа наймаагүйгээр үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болно. Олон улсын худалдаа нь дэлхийн барааны зах зээл дээр харилцан шүтэлцээтэй харилцан хамааралтайгаар тогтнож байгаа билээ. Иймд олон улсын хэмжээнд бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа дэлхийн зах зээл дээр явагддаг. Олон улсын худалдаа хир зэрэг ашигтай явагдах нь зах зээлийн тогтолцоотой нягт уялдаж, харилцан хамаарч зах зээлийн бүрэлдэн тогтолт, хөгжилтөнд шууд нөлөөлдөг хүчин зүйлүүдийн нэг мөн.

Олон улсын худалдааны хөгжил дэвшилд дэлхийн улс орнуудын бараа, таваарын үйлдвэрлэлийн хэмжээ, бүтэц, хүн ам, тэдгээрийг худалдаж авах чадвар; экспорт, импортын өсөлт; барааны үнэ, ханш; худалдааны эрх зүйн баталгаа, хамгаалалт; хөгжингүй орнуудын худалдааны бодлого; шинжлэх ухаан, технологийн дэвшил; бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлдэг.

Олон улсын худалдааны нийт борлуулалтын хэмжээ дэлхийн зах зээлийн багтаамжийг тодорхойлдог учир тухайн үеийн эрэлт хэрэгцээг зөв мэдэрч, түүнийг хангахын тулд экспортер, импортер зах зээлд байраа тогтвортой эзэлж авах явдал чухлаас чухал болно. Барааны эрэлт, нийлүүлэлтийн тухайн үеийн үнийн түвшингээр бүтээгдэхүүний үнэ тогтож байдаг бөгөөд үүнээс үүдэлтэйгээр дэлхийн зах зээлийн дундаж үнийн тухай ойлголт олон улсын худалдаанд зүй ёсоор гарч ирдэг. Олон улсын худалдаанд зонхилох байр эзэлдэг бараа, таваар түүнийг борлуулж буй тэргүүний хөгжилтэй улсуудын үндэстэн дамнасан компаниудын үнэ тогтооход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Ашигласан материал:

1. Олон талт худалдааны хэлэлцээний Урагвайн үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд, МУ-ын Засгийн газар, ДХБ, НҮБ-ын ХХ, Улаанбаатар, 2000 он
2. *Quide to the GATT Law and Practice*, WTO Secretariat, 1994, Geneva,
3. *Practical guide to the WTO laws*, Meeting of African Trade Ministers, Libreville, 2000
4. *Overview of Developments in the International Trading Environment*, Annual Report by Director General WTO|WT|MIN|(01)|2
5. *Investing in Development*, Report th the UN Secretary General Millennium Project, NY, 2005
6. *Human Development Report 2005*, UNDP, NY, 2005
7. *Agreement on Textile and Clothing* WTO Secretariat, 2000, Geneva
8. *Positive Agenda for Developing Countries: Issues for Future Trade and Negotions*, UNCTAD, 1999, Geneva
9. "World Trading System" – What is it all about? www.intracen.org/worldtradenet
10. *Variable Geometry for the WTO: Concept and Precedents* Andrew Cornford, www.unctad.org
11. *Trade Facilitation: The Benefits of Simpler, more Transparent Border Procedure*, www.dataoecd
12. *New Regionalisme: Options for China and East Asia*, Mari Pangestu, CSIS, Jakarta Sudarshan Gooptu, WB
13. *Coverage, liberalization process and Transitional Provision in Regional Trade Agreements*, WTO Secretariat, WT|REG|W|46
14. *The Changing Landscape of Regional Trade Agreements*, Jo-Ann Crawford and Roberto V. Fiorentino
15. www.wto.org
16. *Trade capacity building: Critical for Development*, www.dataoecd
17. *Towards more liberal agriculture trade*, www.dataoecd
18. Коммюнике министров развивающихся стран, не имеющих выхода к морю, ООН, GE.04-70121(R)140604
19. Тарифная среда для экспорта развивающихся стран после урагвайского раунда: Тарифные пики и эскалация тарифов, Совместное исследование ЮНКТАД\ВТО, www.unctad.org TD|B|COM.1|14|Rev.1
20. *L'Avenir de l'OMC: Relever les defies institutionnels du nouveau millenaire*, www.wto.org
21. *Regionalism and Multilateral Trading System*, www.dataoecd
22. *Pacific Economic Outlook*, 2005/2006, PECC
23. *The evolution of PECC: The first 25 Years*, PECC international Secretariat, 2005
24. Доклад о развитии человека за 2003, 2004
25. *Le systeme commercial mondial*, Centre du commerce international, Commonwealth Secretariat, 2000
26. *About GSP*, www.unctad.org/Templates

27. *Accords commerciaux regionaux*, www.wto.org
28. *Brief Analysis of Doha Ministerial Declaration*
29. *South Centre, WTO Secretariat, WT|MIN(01)|DEC|W|1*
30. *International Investment Agreements, Vol. 1-2, www.unctad.org*
31. *The Multilateral Trading System-Past, Present and Future, www.wto.org*
32. *International marketing and trading system ITC, 2000, Geneva*
33. *Business Guide to the GATS ITC and Commonwealth Secretariat, 1999, Geneva*
34. *Accord de l'OMC sur les Textiles et les Vetements Secretariat de l'OMC, 2000, Geneva*
35. *Trade related Investment Measures and other Performance Requirements WTO Secretariat, G|C|W|307|add1*
36. *Rules of Origin Regimes in RTA WTO Secretariat, WT|REG|W|45*
37. *Research and Training Tools on Tariff peaks and other Residual trade Protection, Commercial Diplomacy Programme, UNCTAD, www.unctad.org/commdip*
38. *Basic Information on RTA WTO Secretariat, WT|REG|W|44*
39. *Trade Policy for Developing Countries in a Global Economy: Hand book Development Research Group and WB Institute, WB, 2001*
40. *FDI and Trade-two way linkage? Joshua Aizenman, Ilan Noy, June 2005, http://www.nber.org/paper/w11403*
41. *Э.Гүргэмжав, Гадаад худалдаа: Онол арга зүйн үндэс УБ, 1997*
42. *Международная Экономика, Миклашевская Н.А., Холопов А.В., МГУ, 2000*
43. *Mapping of Regional trade Agreements WTO Secretariat, WT|REG|W|41*